

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2010 оны 5 дугаар сар

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2010 оны 5 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлт дараах байдалтай байна. Үүнд :

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өөрчлөлт	/тоогоор/			2010-V
		2010-IV	Нэмэгдсэн	Хасагдсан	
1	Даатгалын компани	16	0	0	16
2	Даатгалын компанийн салбар	132	2 ¹	0	134
3	Даатгалын төлөөлөгч	1872	134 ²	0	2006
4	Даатгалын зуучлагч	7	0	0	7
5	Даатгалын хохирол үнэлэгч	5	1 ³	0	6
6	Актуарч	10	0	0	10
7	Аудитын компани	20	0	0	20
8	Аудитор	46	0	0	46
9	Бусад өөрчлөлт : хувь нийлүүлэгч /2/		2 ⁴		

Тайлант үед даатгалын компани, даатгалын зуучлагч, актуарч, аудитын компани болон аудиторуудын тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹Хорооны даргын 2010 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 85 дугаар тушаалаар “Миг даатгал” ХХК-д Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт, мөн 2010 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 71 дүгээр тушаалаар “Прайм женерал даатгал” ХХК-д Булган аймагт даатгалын компанийн салбар нээх зөвшөөрөл олгосон байна.

²Харин даатгалын төлөөлөгчийн хувьд “Монгол даатгал”ХХК /88 иргэн/, “Практикал даатгал” ХХК /46 иргэн/-ийн нийт 134 иргэнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны даргын тушаалаар олгосноор 2010 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 2006 даатгалын төлөөлөгчтэй болсон байна.

³Мөн Хорооны 2010 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 135 дугаар тогтоолоор “Мега марз” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноор даатгалын хохирол үнэлэгчдийн тоо 2010 оны 5 дугаар сарын байдлаар 6 болсон байна.

⁴Хорооны 2010 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 134 дүгээр тогтоолоор “Гранд даатгал” компанийн гүйцэтгэх захирлаар В.Гэрэлт-Од, нягтлан бодогчоор Д.Дашням нарыг томилохыг зөвшөөрсөн байна.

Хорооны даргын 2010 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 86 дугаар тушаалаар “Гранд ко даатгал” ХХК-ийн оноосон нэрийг өөрчилж “Гранд даатгал” ХХК болгожээ.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2010 оны 5 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулбал:


Ердийн даатгалын компаниудын хувьд :

/мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2009-V	2010-V	Өөрчлөлт /Хувиар/
1	Даатгалын нийт хураамж	1 782 770,7	2 368 975,4	32,9%
2	Олгосон нийт нөхөн төлбөр	439 751,7	529 852,6	20,5%
3	Давхар даатгалд төлсөн хураамж	386 433,5	52 103,6	-86,5%
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	16684	21395	28,2%
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	7 425 600,0	25 818 851,6	247,7%
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	46 776,9	40 000,0	-14,5%

Хамгийн их дүнтэй даатгалын нөхөн төлбөрийг “Прайм женерал даатгал” ХХК “НИК” ХК-ийн хангайн бүс салбарт тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний нөхөн төлбөрт 40,0 сая төгрөг олгосон байна.

Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, давхар даатгалд төлсөн хураамж, сая төгрөгөөр



2010 оны 5 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 586,1 сая төгрөгөөр буюу 32,9 хувиар, олгосон даатгалын нөхөн төлбөр 90,1 сая төгрөгөөр буюу 20,5 хувиар өссөн байна. Харин давхар даатгалд төлсөн хураамж 334,3 сая төгрөгөөр буюу 86,5 хувиар буурсан байна. Тайлант үед шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн 74,62 хувь буюу 38,9 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК шилжүүлсэн байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд : /мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2009-V	2010-V	Өөрчлөлт /Хувиар/
1	Даатгалын нийт хураамж	4 555.8	6 392.1	40,3%
2	Олгосон нийт нөхөн төлбөр	0,00	3 900.7	100,0%
3	Давхар даатгалд төлсөн хураамж	0,00	0	0,0%
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	3	9	200,0%
	Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд	0	8	100,0%
	-Байгууллагын хугацаат даатгалд	3 гэрээ (35 хүн)	1 гэрээ (74 хүн)	111,4%
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д	0	0	0,0%
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	50000.0	15 000 .0	-70,0%
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	0,00	760.0	100,0%

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2010 оны 5 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2009 оны мөн үеийнхтэй харьцуулж үзэхэд даатгалын хураамжийн орлого 1,8 сая төгрөгөөр буюу 40,3 хувиар нэмэгдсэн байгаа ба энэ нь тус компанийн хураамжийн орлого төдийлөн хангалттай нэмэгдэхгүй байгааг харуулж байна.

Харин даатгалын нөхөн төлбөр 2009 онд огт гараагүй бол 2010 оны 5 дугаар сард 3,9 сая төгрөгийн нөхөн төлбөр гарсан нь хойшид нөхөн төлбөр ихээр нэмэгдэх шинжтэй байгааг харуулж байна. Нөхөн төлбөрийн хувьд өндөр хамгаалалттай эрүүл мэндийн даатгалаар 1,3 сая төгрөг, эмнэлгийн мөнгө нэмэлт нөхцөлөөр 2,5 сая төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдалтын нэмэлт нөхцөлөөр 0,1 сая төгрөг, нийт 3,9 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд : /мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2010-III	2010-IV	2010-V
1	Даатгагчид дамжуулан шилжүүлсэн даатгалын хураамж	15 865,7	103 228,2	49 451,4
2	Даатгалын зуучлагчийн орлого	7 435,1	30 997,9	12 533,8
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	29,00	50,00	16,00
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	2 954 787,5	3 567 401,6	3 420 609,9

2010 оны 5 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 3,4 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 16 даатгалын гэрээг даатгалын компаниудад зуучилж 12,5 сая төгрөгийн зуучлалын орлого олж даатгалын зуучлалын орлого 4 дүгээр сарынхаас 59,5 хувиар буурсан байна.

Даатгалын зуучлагчийн орлогын 66,4 хувийг “Лояалти Солюшн” ХХК, 22,4 хувийг “Ачит ундарга” ХХК, 11,2 хувийг “Реннесанс” ХХК төвлөрүүлж ажилласан бол “Эм Жи Ай Би” ХХК, “Аме” ХХК, “Скай эрдэнэ” ХХК нь даатгалын зуучлалын орлого олоогүй байна.

2010.06.14